

СУМЫН ЗДТГ-ЫН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

ЗДТГ-ын зорилт:

- Хариуцлагатай төрийн албан хаагч байх
- Ажлын арга барилаа шинэчилж албан хаагч бүр манлайлагч болох
- Иргэдээ дээдэлж тэдний оролцоог хангасан ил тод нээлттэй байх
- Иргэн бүрт хүрч ажиллах

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хэрэгжилт	Хувь
Нэг. Төрийн захиргаа, хууль эрх зүй, удирдлага зохион байгуулалт, дотоод ажлын хүрээнд				
1.	ЗДТГ-ын ажилтан албан хаагчдын шуурхай хурлыг тогтмол зохион байгуулах	Үйл ажиллагаа тогтмолжсон байх	Ажилтан албан хаагчдын шуурхай хурлыг долоо хоног бүрийн Даваа гарагийн 9 цагт тогтмол хийж өнгөрсөн 7 хоногт хийж хэрэгжүүлсэн ажил ирэх 7 хоногт хийх ажлын төлөвлөгөөгөө хэлэлцэж байна.	100%
2.	ЗДТГ-т мөрдөгдөж буй дүрэм, журмуудад ажилчдын саналыг тусган өөрчлөлт оруулах		ТАХ-ын ёс зүйн дүрэм, дотоод журам, хамтын сангийн журам, дотоод хяналтын нэгжийн ажиллах журам зэрэг дүрэм журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна. Дотоод журмыг 2018 оны 3, 9 сард нийт албан хаагчдаар хэлэлцүүлэн шинэчлэн баталсан.	100%
3	ЗДТГ-н төрийн захиргааны ажиллагсадтай Үр дүнгийн гэрээ байгуулах, үйлчилгээний ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж биелэлт үр дүнг тооцож ажиллах	Гэрээ байгуулж хагас бүтэн жилээр биелэлт үр дүнг тооцсон байх, ажлын хариуцлага сайжирсан байх	2018 оны 3 сард төрийн захиргааны ажиллагсадтай үр дүнгийн гэрээ, үйлчилгээний ажилчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулсан. Албан хаагчидтай хагас бүтэн жилээр үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээг дүгнэсэн.	100%
4	Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийж ажил үүргийн давхардал, хийдэгдлийг арилгах, шинэчлэх	Ажил үүргийн давхардал хийдэгдэл гарахгүй байх,	ТГ-ын даргын тушаалаар бүх төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийж дахин боловсруулах ажлын хэсгийг томилж нийт 18 албан хаагчдад ажлын байрны тодорхойлолтыг танилцуулж гарын үсэг зуруулж баталгаажуулсан.	100%
5	Монгол Улсын Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг заалт бүрээр хяналтанд авч биелэлтийг албан хаагчдаас авч нэгтгэн тайлагнах	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг заалт бүрээр хяналтанд авч биелэлтийг албан хаагчдаас авч нэгтгэн тайлагнаж хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 88,3%-тай байна.	100%
6	Аймаг, сумын нийгэм, эдийн засийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг сумын ИТХ-д тайлагнах	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	Аймаг, сумын нийгэм, эдийн засийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг байгууллага, албан хаагчдаас авч нэгтгэн тайлагнаж хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 91,5%-тай байна. хэрэгжилтийг гарган аймгийн ХШҮДАХ болон сумын ИТХ-д хүргүүлсэн	100%
7	Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан гэрээг хяналтанд авч биелэлтийг тооцож ажиллах	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	Аймгийн Засаг дарга сумын Засаг даргатай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээг хяналтанд авч биелэлтийг тооцож аймгийн ХШҮДАХ-т хүргүүлсэн. Хэрэгжилт 90.5%	100%

8	Хууль эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөө гарган биелэлт үр дүнг тооцон ажиллах	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	“Бүх нийтийн эрх зүйн боловсрол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулсан. Мөн энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗДТГ-ын даргаар ахлуулсан “Эрх зүйн хөтөч” багийг шинэчлэн томилсон. Эрх зүйн хөтөч баг хууль эрхзүйн сургалт сурталчилгаа хийх жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллалаа. Сумын эрх зүйн хөтөч багаас 2018 онд судлан сурталчлах хууль эрх зүйн актын төлөвлөгөөнд 21 хууль тогтоомжийг судлуулахаар төлөвлөсөн. Үүнээс 11 сарын эцсийн байдлаар 14 хууль тогтоомжийг төрийн албан хаагчдад танилцуулж давхардсан тоогоор 208, төлөвлөгөөнөөс гадна 9 удаагийн мэдээлэл сургалтанд давхардсан тоогоор 216 иргэд, төрийн албан хаагч хамрагдсан.	100%
9	Дотоод хяналт шалгалтын нэгж байгуулан төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажиллах	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	ТГ-ын даргын тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын нэгжийг томилж төлөвлөгөөг батлуулан ажилласан. Дотоод хяналт шалгалтыг төлөвлөгөөний дагуу 3 удаа хяналт шалгал хийж нийт ажилчдаас сэтгэл ханамжийн судалгаа аван үүний дагуу ажлын байрыг тохижуулах тал дээр анхааран ажилласан. Мөн мэргэжилтэн тус бүрт цаашид анхаарч ажиллах тал дээр зөвлөмж өгсөн.	100%
10	ХШҮ-ээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж үр дүнг тооцох	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	Аймгийн ХШҮДАХ-ээс 2017 оны жилийн эцсээр өгсөн зөвлөмжийн дагуу 33 заалт бүхий ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллахад хэрэгжилт 92,7%, 2018 оны хагас жилийн ХШҮ-ний дагуу өгсөн зөвлөмжийн дагуу 28 заалт бүхий боловсруулан хэрэгжилтийг тооцож хэрэгжилт 90,3%-тай байна.	100%
11	Авлигын эсрэг ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллах	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	ЗДТГ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018 оны 1 сард Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар тооцон гаргахад 95,1%-тай хэрэгжсэн байна. Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтонд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж ил тод нээлттэй байх заалтыг оруулж өгсөн. Энэ онд шинээр томилогдсон 3 улс төрийн албан хаагчийн урьдчилсан мэдүүлгийг АТГ-ын дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтэст материалыг хүргүүлэн ашиг сонирхлын зөрчилгүй тухай албан тоот ирсний дараа томилсон.	100%
12	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь гаргаж нэгтгэн тайланг цахимд шивэх, өөрчлөлт хөдөлгөөнийг хийх	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	Оны эхэнд ХОМ гаргах 7 төрийн албан хаагчийн судалгааг ХЭЗХ-т хүргүүлэн. Төрийн албан хаагчдын ХОМ-ыг хуулийн хугацаанд авч мэдүүлгийн программд шивсэн. 2018 шинээр томилогдсон 3 улс төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-т хянуулсны үндсэн дээр тухайн албан тушаалуудад томилсон. Мөн эдгээр албан хаагчдийн ХОМ-ыг томилогдсоноос хойш 30 хоногт багтаан хуулийн хугацаанд гаргаж ИТХ-ын ЭБАТ-д мэдүүлсэн.	100%

13	Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг гарган цахимд шивэх	Хугацаанд нь өгсөн байх	Төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг гарган цахимд шивж баталгаажуулан хүлээлгэн өгсөн.	100%
14	Өмч хамгаалах зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж тайлагнах	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөөг сумын Засаг даргаар 2018 оны 03-р сарын 20-ны өдөр батлуулсан. Байгууллагын эд хөрөнгийн хагас бүтэн жилийн тооллогыг 6, 12 сард тушаалаар комисс томилон ажиллуулж холбогдох материалыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөлд хүргүүлж ажилласан.	100%
15	ЗДТГ-н ажилтнууд болон төсвийн байгууллагын дарга нарт хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрийн жагсаалтыг гарган хүргүүлэх	Жагсаалтыг гаргаж хүргүүлсэн байх	Оны эхэнд ЗДТГ-н ажилтнууд болон төсвийн байгууллагын дарга нарт хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрийн жагсаалтыг гарган хүргүүлж хагас бүтэн жилээр хэрэгжилтийг тооцож ирүүлж байх талаар чиглэл өгсөн.	100%
16	Суманд хэрэгжих үндэсний болон дэд хөтөлбөрийн төлөвлөгөөг гарган батлуулж биелэлтийг тооцож тайлагнах	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	Суманд хэрэгжих үндэсний 31, дэд 13 хөтөлбөрийн төлөвлөгөөг байгууллагын дарга болон холбогдох мэргэжилтнээр гаргуулан батлуулж биелэлтийг хагас бүтэн жилээр тооцож ажиллалаа.	70%
17	Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний чанар хүртээмж, байгууллага, албан хаагчдын талаар иргэдээс сэтгэл ханамжийн үнэлгээг авч дүгнэлт хийж ажиллах	Судалгааг авч үнэлгээ дүгнэлт гаргах	Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний чанар хүртээмж, байгууллага, албан хаагчдын талаар иргэдээс сэтгэл ханамжийн үнэлгээг авах зорилгоор сумын Залуучуудын холбоотой гэрээ байгуулан нээлттэй хаалганы өдөрлөгөөр иргэдээс 10 асуулттай санал асуулгыг авахад 50 иргэн хамрагдаж ЗДТГ-ын тохижилт ажиллах орчин нөхцөл, ил тод байдлын хувьд 45% нь хэвийн, 25% нь цаашид анхаарч сайжруулах шаардлагатай гэж үзсэн бол ЗДТГ-ын ажилтан албан хаагчдын хувьд 35-50% нь үйлчилгээний чанар, шуурхай байдал, мэдлэг ур чадвар, харилцаа ёс зүй зэрэг асуудлууд дээр хэвийн болон цаашид анхаарч сайжруулах нь зүйтэй гэсэн байлаа. Мөн иргэдээс санал авахад 25 иргэн санал өгч 44% нь дэлгүүрүүдийг НӨТ-ийн баримт олгуулах ажлыг зохион байгуулмаар байна гэж үзсэн байна. Дээрх санал асуулгын дагуу холбогдох арга хэмжээнүүдийг авч мэргэжилтнүүдэд үүрэг чиглэл өгч ажилласан. 2018 оны жилийн эцсийн мал тооллогоор иргэдээс санал асуулга авч ажилласан.	100%
18	Иргэдийг мэдээ мэдээллээр хангах зорилгоор хийсэн ажлын талаарх тайлан бүхий сонин сэтгүүл гаргаж өрх бүрт хүргэх	Ажил зохион байгуулсан байх	2018 оны 1-р сард 2017 оны жилийн ажлын тайлангаар “Цагаандэлгэр-2017” сэтгүүл гарган хэвлүүлж сумын 400 өрхөд тарааж ажилласан. Энэ ажилд 1400,0 төгрөг зарцуулсан.	100%
19	“Цагаандэлгэрийн мэдээ” фасебүүк хуудас, аймгийн www.dundgovi.gov.mn вэбсайт болон ЗДТГ-ын зарлалын урсдаг самбараар мэдээ мэдээллийг иргэдэд тогтмол шуурхай хүргэж байнга шинэчлэх	Иргэд мэдээ мэдээллээр бүрэн хангагдсан байх	АБХЭрхлэгч урсдаг самбар болон аймгийн мэдээллийн сайтад мэдээ мэдээллийг оруулж сурталчилж байна. Сумын “Цагаандэлгэрийн мэдээ” группыг ажиллуулж мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэж байна.	100%

20	Малчид иргэдэд мессеж мэдээ хүргэх ажлыг зохион байгуулах	Иргэд мэдээ мэдээллээр бүрэн хангагдсан байх	Цаг агаарын гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх АС цогцолборын үйл ажиллагааг тогтмолжуулж малчдыг радиожуулах ажлын хүрээнд 15 өрхөд байршуулж цаг агаарын мэдээ мэдээллийг тогтмол өгч ажиллаж байна. Малчдын утасны жагсаалтыг цаг уурын өртөөнд тухай бүр шинэчлэн өгч масс мессежийн үйлчилгээг үзүүллээ. Масс мессеж үйлчилгээний зардал болох 120000 төгрөгийг ЗДТГ-аас олгож ажилласан.	100%
21	89553330 дугаарын утсаар иргэдийн санал, хүсэлтийг тогтмол авч шийдвэрлэх	Санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байх	ЗДТГ-т ӨГСХ хүлээн авах 7059106, 89643553 дугаарын утсыг ажиллуулж иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч холбогдох албан тушаалтанд хүргүүлж хариуг хуулийн хугацаанд хүргүүлж байна.	100%
22	Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлүүлэх	Санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байх	Сумын хэмжээнд 2018 оны байдлаар 335 өргөдөл ирснээс 331 өргөдлийг хуулийн хугацаанд нь шуурхай шийдвэрлэсэн бөгөөд судлагдах шатандаа байгаа 4 өргөдөл байна. Үүнээс: Засаг дарга, түүний тамгын газарт хандан 2018 оны байдлаар 257 өргөдөл ирснээс өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн бөгөөд судлагдах шатандаа байгаа 4 өргөдөл байна. Ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд 13 санал, өргөдөл, гомдол, Соёлын төвийн хүрээнд 4 санал, өргөдөл, гомдол, Хүүхдийн цэцэрлэгийн хүрээнд 35 санал, өргөдөл, гомдол, Эрүүл мэндийн төвийн хүрээнд 22 санал, өргөдөл, гомдол ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	100%
23	Тайлан мэдээ, хариутай бичгийн биелэлтийг хугацаанд нь гаргаж хүргүүлэх	Тайлан мэдээ хугацаандаа гарсан байх	Able программаар нийт 2831 баримт бичиг ирсэн байна. Үүнээс файлын санд-404, зар мэдээ-861, захидлаар -1514, албан бичгээр-50 ирснийг хууль журмын дагуу хугацаанд нь захирдлаар 273 албан бичгийн явуулж, Засаг дарга, Тамгын газрын даргын албан бичгээр 266 бичгийн хариуг дээд байгууллагад цаг хугацаанд нь явуулж ажиллалаа.	100%
24	Байгууллагынхаа албан хаагчдын сургалтын болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцох	Хөтөлбөр хэрэгжсэн байх	ЗДТГ-т ТАХ-ын сургалтын хөтөлбөрийг боловсруулан 2018 онд 12 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан. Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх тал дээр онцгой анхаарч, дээд газрын графикт сургалтанд төрийн албан хаагчдыг шат дараалан хамруулсан байна. ЗДТГ-ын жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн Ц.Ундрахбаяр нь ХААИС-д эчнээгээр суралцаж байна. Суралцах хугацаанд цалинг олгож дэмжиж ажиллаж байна. Сумын удирдлагууд мэргэжилтнүүдээ чадавхжуулах тал дээр анхаарч Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн ЗДТГазартай шифийн холбоо тогтоож харилцан туршлага солилцох уулзалт арга хэмжээнд байгууллагын дарга эрхлэгч, багийн Засаг дарга нар оролцож ирсэн. Тамгын газрын албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхээр сумын эрүүл мэндийн төвийн НЭМС-ийн ажилтан Г.Энхжаргалтай хамтран байгууллагын	100%

		ажилтан албан хаагчдад “Эрүүл байхын үндэс”, “Эрүүл мэнд гэж юу вэ? гэсэн 2 сэдвээр сургалт зохион байгуулж ажилчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч ажиллалаа. Их эмч А.Өлзийжаргал “Тамхины хор хөнөөл”, ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Бямбасүрэн “Архины хор хөнөөл” сэдвээр сургалт хийж албан хаагчид хамрагдсан. Шинээр ажилд орсон 3 ажилтан албан хаагчдыг ажлын байранд нь сургахад анхаарч туршлагатай албан хаагчийг дагалдаж сурах үүрэг чиглэлийг тогтмол өгч байна. Мөн үүрэгт ажлын чиглэлээр нь хувьд холбогдох сургалт семинарт тухай бүр хамруулж байна. Эрх зүйн хөтөч багаас 2018 онд судлан таниулах сургалтын төлөвлөгөөг оны эхэнд батлан холбогдох мэргэжилтэн, албан хаагчдаар сургалт мэдээллийг хуваарийн дагуу долоо хоног бүрийн Лхагва гарагийн 10цагт зохион байгуулж хэвшсэн ба байгууллагын ажилчид тогтмол хамрагдаж хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэн ажиллаж байна. ТАХ-ын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд УИХ, ЗГ-аас баталсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож мөрдөж ажиллалаа. ЗДТГ-ын даргын тушаалаар албан хаагчдад холбогдох нэмэгдлийг олгуулж ажиллалаа. Үүнд: - Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 4 албан хаагчид олгож 1209410 төг, - Зэрэг дэвийн нэмэгдэл 2 албан хаагчид олгож - Цалингийн шатлалыг 2 албан хаагчид ахиулж олгосон боловч УИХ-ын 2017 оны 29-р тогтоолын дагуу түр зогсоосон. - Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл 2 албан хаагчид олгож 2653494 төг, Ур чадварын нэмэгдэл 4 албан хаагчид олгож 3273940 төг тус тус зарцуулсан байна. Байгууллагын дотоод журмыг үндэслэн Тамгын газрын албан хаагчдын 2018 оны ээлжийн амралтын хуваарийг гарган бүх албан хаагчийн ээлжийн амралтыг биеэр эдлүүлсэн. Улсын бүртгэгч Д.Бат-Оршиход шинэ гэр барихад нь 200000 төг, МЭҮТ-ийн дарга Т.Өлзийбатын шинэ төрсөн хүүхдэд 100000 төг, ар гэрийн гачигдал гарсан 5 албан хаагчид 360000 төг, 2 албан хаагчид УБ хотод эмчилгээ оношилгоонд явахад 80000 төг, 3 албан хаагчийг эмнэлэгт хэвтэхэд 90000 төгрөгийг тэтгэмж тусламж үзүүлсэн байна. 12 сард 17 албан	
--	--	--	--

			хаагчид түлээ нүүрсний хөнгөлөлтөнд 510000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Компьютерийн техник хэрэгслийн ашиглалтанд хяналт тавин компьютер техник хэрэгсэл, интернэтийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна. Энэ онд Тамгын газрын үйл ажиллагаанд нийт 20 компьютер, 15 принтер ашиглагдаж байна. Техник хэрэгслийг шинэчлэх засварлахад байгууллагаас 14200,000 төгрөг гарган шийдвэрлэлээ. Албан хаагчдын ая тухтай ажиллах нөхцөл бололцоог хангах, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэн өөрсдийн нөөц боломжид тулгуурлан дотоод засвар үйлчилгээг хийж, өрөө тасалгааны үйлчилгээнд анхааран ажиллаж байна. Ажлын байрны орчин нөхцлийг засварлах, сайжруулах ажлын хүрээнд байгууллагаас 400,000 төгрөгийг зарцууллаа. Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний мэдлэг боловсролоо дээшлүүлэх ажлын хүрээнд ЖДҮ хариуцсан мэргэжилтэн Ц.Ундрахбаярыг ХААИС-д суралцахад цалинтай чөлөө олгож, Засаг даргын орлогч Н.Өнөржаргалыг УБ хотод нутгийн удирдлагын холбооноос зохион байгуулсан сургалтны төлбөр 80000 төгрөгийг байгууллагаас гаргаж дэмжлэг үзүүлж ажиллав. ЭМТ-өөс явуулсан сургалтуудад албан хаагчдыг тухай бүр хамруулж, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хүрээнд В С вирусыг илрүүлэх шинжилгээнд 15-39 насны албан хаагчдыг 100% хамруулсан. Эрүүл цус аяны хүрээнд ДОХ тэмбүүгийн илрүүлэг үзлэг шинжилгээнд албан хаагчдыг 100% хамруулж ажилласан. 2018 оны 6 сард аймгийн НЭ-ийн явуулын амбулатороор албан хаагчдаа хамруулсан байна. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 5 албан хаагчдад хамтын сан болон ажилчдаас 170000 төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн байна. Хаан банк, төрийн банктэй гэрээтэй ажиллаж албан хаагчдад шаардлагатай хэрэгцээтэй үед цалингийн зээлийн тодорхойлолт гарган өгч дэмлэг үзүүлж ажилласан.	
25	Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах	Ажил зохион байгуулсан байх	2018.04.18-нд нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж нийт 82 иргэн хамрагдсан байна. өдөрлөгөөр ЗДТГ-ын 2018 оны 1-р улирлын ажлын тайланг танилцуулсан мөн 2018 оныг аймгийн хэмжээнд эрүүл мэндийг дэмжих жил, сумын хэмжээнд бүтээн байгуулалтын жил болгож зарласантай холбогдуулан дээрх ажлын жилүүдийн нээлтийг хийсэн. Улсын бүртгэл, нийгмийн даатгалын нээлттэй өдөрлөгийг зохион байгуулсан.	70%
26	ЗДТГ-ын байранд засвар үйлчилгээ хийх, хашааны ойр орчмын хог хаягдал, өрөө тасалгааны цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийх	Өнгө үзэмж сайжирсан байх	2018 оны 3 сард малчдын зөвлөгөөн, 5,10 сард бүх нийтийн цэвэрлэгээ хийхтэй холбогдуулан ЗДТГ-ын болон агуулах складны ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэсэн. Өрөө тасалгааны цэвэрлэгээ үйлчилгээг батлагдсан хуваарийн дагуу тогтмол хийж байна.	100%
27	Аль нэг сумтай очиж туршлага судлах	Туршлага болох	Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 10 дугаар хороотой шифийн харилцаа тогтоосон. Энэ ажлын эхлэл болгож 9 сарын 17-	100%

			нд 10-р хорооны 45 ахмадыг орон нутагтаа хүлээн авч сумын ахмадын хороотой хамтран Ахмадын баяраа хамтран тэмдэглэсэн. Мөн Баянзүрх дүүргийн ЗДТГ, 10-р хороотой туршлага судлах арга хэмжээг 10 сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулж сумын удирдлагууд оролцож туршлага судалж ажилласан байна.	
28	Албан хаагч бүрээр жилийн ажлын төлөвлөгөө гаргуулан батлах, сар бүрийн хийх ажлын төлөвлөгөөг төлөвлүүлж батлан биелэлт үр дүнг тооцож ажиллах	Ажлын хариуцлага хяналт сайжирна.	Албан хаагч бүрээр жил, улирлын ажлын төлөвлөгөө гаргуулан баталж биелэлт үр дүнг улирал бүр тооцож ажиллалаа.	100%
29	Үйлчилгээний ажилчдын ажлыг сар бүр ажил дүгнэх хуудсаар үнэлж дүгнэх	Ажлын хариуцлага хяналт сайжирна.	Үйлчилгээний ажилчдын ажлыг дүгнэх аргачлалыг баталсан. Үүний дагуу сар бүр ажил дүгнэх хуудсаар ажлаа дүгнүүлж тайлангаа ирүүлсэн албан хаагчдын ажлыг үнэлж дүгнэн холбогдох урамшууллыг өгч ажилласан.	100%
30	Байгууллагын үйлчилгээний стандартыг боловсруулан мөрдөж ажиллах	Стандарт хэрэгжсэн байх	Хэрэгжээгүй	0
31	ИТХ, тэргүүлэгчдийг хийсэн ажлын талаарх тайлан мэдээллээр хангаж ажиллах	Ажлын уялдаа холбоо сайжирч мэдээллээр хангагдана.	ИТХ, тэргүүлэгчдийг хийсэн ажлын талаарх тайлан мэдээллээр хангаж ажилласан байна.	100%
32	Ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэн, жилийн ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг тооцон ажиллах төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэхэд чиглүүлж, албан хаагчдын ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх	Хэрэгжилтийг тооцож үр дүнд хүрсэн байх. Ёс зүйн зөрчил дутагдлын тоо буурч, соён гэгээрүүлэх ажил арга хэмжээ авсан байх	Байгууллагынхаа дэргэд ёс зүйн хороог шинэчлэн байгуулж ажлын төлөвлөгөөг батлан ажиллаж байна. Бүх мэргэжилтэн, ажилтнуудтай ёс зүй хариуцлагын гэрээг байгуулсан. Ёс зүйн зөрчил гаргасан 2 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой 1 гомдол ирснийг ёс зүйн хороонд шилжүүлж шийдвэрлэсэн.	100%
Хоёр. Цэрэг, батлан хамгаалах, гамшгаас хамгаалах ажил үйлчилгээ				
1.	Цэргийн албаны тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуулийн сурталчилгааг зохион байгуулан 18-50 насны эрчүүдийг ЦШБ-д бүртгэж, мэдээллийн санд бүрэн хамруулах, цэргийн насны залуучуудыг цэргийн жинхэнэ албанд татах ажлыг чанартай зохион байгуулах	Хуулийг хэрэгжүүлсэн байх	Сумын Засаг даргын захирамжаар 2018 оны цэргийн тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг байгуулан шинэчилсэн тоо бүртгэлийг явуулж тайлан мэдээг аймгийн Цэргийн штабт хүлээлгэн өгсөн. 2018 оны 2-р ээлжийн цэрэг татлага Говь-Угтаал суманд 10-р сарын 07-ны өдөр зохион байгууллаа. Цэрэг татлагын комиссоор нийт 28 цэрэг орж 1 цэрэг тэнцэж цэрэгт мордсон.	100%
3.	Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, сэрэмжлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Үйл ажиллагааг зохион байгуулсан байх	Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 1-р сард тодотгож мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг тодотгосон. 3 сарын 29-нд зардан мэдээллийн дохиогоор ажиллах журмын дагуу серень дохиог ажлуулж сургалтанд 82 иргэн 8 машин техник хамрагдсан. 5 сарын 8-9-нд аймгийн Онцгой байдлын газраас гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулж үзлэгт сумын	100%

			мэргэжлийн анги бүрэн оролцож, багаж техник хэрэгслийн бэлэн байдлаа хангаж ажилласан.	
4.	Батлан хамгаалах хууль, тогтоомж, бодлого, үйл ажиллагааг сурталчлан хэрэгжүүлж, цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, боловсролын түвшинг дээшлүүлэн цэрэг эх оронч үзлийг төлөвшүүлэх	Үйл ажиллагааг зохион байгуулсан байх	Цэргийн насны иргэнийг эрүүлжүүлэхэд анхаарч цэрэг татлагаар эрүүл мэндийн байдлаас болж чөлөөлөгддөг 8 иргэний судалгааг аймгийн Цэргийн штабт болон сумын ЭМТ-т гаргаж хүргүүлсэн. үүний дагуу сумын ЭМТ-өөс эдгээр цэргүүдийг эрүүлжүүлэх арга хэмжээг авч тайланг ЦШ-т хүргүүлсэн. 2018 оны 2-р ээлжийн цэрэг татлагаар буюу 10 сарын 07-ны цэргийн насны залуучуудад цэргийн албаны тухай хууль болон насан туршийн боловсролын нэгжээс цэрэг эрх оронч үзлийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан.	100%
Гурав. Эдийн засаг, төсөв санхүү, татварын хүрээнд				
1.	Төсвийн шууд захирагч төсвийн ерөнхийлөн захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулах	Гэрээ байгуулсан байх	2018 оны 3 сард сумын Засаг дарга буюу төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн шууд захирагч нартай үр дүнгийн гэрээ байгуулсан.	100%
2	Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн төсвийн шууд захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулах, нягтлан бодогчид, нярав хөдөлмөрийн гэрээ байгуулах	Гэрээ байгуулсан байх	ЗДТГ-ын дарга 2018 оны 3 сард санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн төсвийн шууд захирагчтай үр дүнгийн гэрээ, нягтлан бодогчид, нярав хөдөлмөрийн гэрээ байгуулсан.	100%
3	Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэх	Бодлогын баримт бичигтэй болсон байх	2017 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/39 тоот тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг томилон ажиллуулж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан.	100%
4	Байгууллагуудын дарга, нягтлан, нярав нарт сургалт зохион байгуулах	Сургалт зохион байгуулах	Албан байгууллагуудад мэдээллийн цагаар Төсвийн тухай хууль, 2017, 2018 оны төсвийн чиг хандлагын талаар мэдээлэл, сургалт хийж нийт 20 гаруй албан хаагч нар хамрагдлаа. 10 сарын 8-9-нд ОНӨГ-аас зохион байгуулсан хөрөнгийн дахин үнэлгээний аргачлалын сургалтанд төсвийн байгууллагын дарга, нягтлангууд, санхүүгийн албаны дарга хамрагдсан. Мэдээллийн цагаар дээрх сургалтаар байгууллагын няравууд болон бусад албан хаагчдад сургалт зохион байгуулсан.	100%
5	Байгууллагуудын нягтлан, няравын үйл ажиллагааг шалган зөвлөн туслах	Алдаа дутагдал гараагүй байх	2018 оны 2,4-р улиралд Байгууллагын дотоод хяналт шалгалтаар Санхүү албаны дарга Ё.Мядагмаа, 2-р багийн засаг дарга Н.Батгэрэл, МЭҮТДарга Т.Өлзийбат нар байгууллагын дотоод үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж нярав, нягтлангийн өдөр тутмын үйл ажиллагаа агуулахын эмх цэгц, бараа материалын тооцоо бодолтуудыг шалган зөвлөгөө зөвлөмж өгч байгууллагын хурлаар шалгалтын дүнг танилцуулж хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Үүний үр дүнд агуулахын эмх цэгц, агуулахын бүртгэл хөтлөлт сайжирч сар бүрийн эцэст нярав, нягтлан 2 бараа материалын тооцоо нийлж тайлан мэдээгээ гаргадаг болсон.	100%

6	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, журмын дагуу мэдээллийг хугацаанд нь сайтад байршуулж ил тод байдлыг хангаж ажиллах	Ил тод байдал хангагдсан байх	2018 оны 1-р сард байгууллагын дарга нарт шилэн дансанд цаашид хэрхэн мэдээлэл тавих талаар зөвлөмж өгсөн. Уг хууль нь хэрэгжиж эхлэсэнээс хойш 3 жил болж байгаа ба мэдээ мэдээлэллээ хэрхэн яаж байршуулах талаар байгууллагын дарга, нягтлан бодогчдод сургалт мэдээллийг тогтмол өгч ажилладаг. 1 албан хаагчид хариуцлага тооцсон. Шилэн дансны мэдээллийг shilendans.gov.mn сайтад холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар журмууд, шилэн дансны хуулийн дагуу хуулийн хугацаанд мэдээллүүдийг байршуулж байна. Байгууллагын санхүүгийн мэдээллийг www.shilendans.gov.mn болон мэдээллийн самбарт сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүжилтийн хуваарь, аудитын дүгнэлт бусад санхүүтэй холбогдолтой мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулан архивийн нэгж үүсгэн ажиллаж байна.	100%
7	Төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган төсвийн тайланг сар, улирал, жилээр гарган нийтэд мэдээлэх	Ил тод байдал хангагдсан байх	Сар бүрийн 2-ны дотор сарын мэдээг нягтлан бодогчдоор гаргуулан байгууллагын дарга нараар баталгаажуулсаны үндсэн дээр Төрийн сангийн мэргэжилтэн хянан баталгаажуулж Санхүү албаны дарга мэдээний нэтгэлийг гаргаж программд шивж оруулж байна. Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг байгууллагын Санхүүгийн мэдээллийн самбарт байршуулан олон нийтэд мэдээлэн мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна. Мөн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайланг шилэн дансанд байршуулж байна.	100%
8	Төрийн сан болон төсөвт байгууллагын санхүүгийн баримтыг архивлах		Төрийн сангийн 2018 оны мемориалын 1-7 сарын баримтыг аймгийн төрийн сангийн мэргэжилтэнгээр шалгуулсан. Өгсөн зөвлөмжийн дагуу баримтыг үдэж цэгцлэн сумын архивт 100 хувь хүлээлгэн өгсөн.	100%
9	2019 оны төсвийн төсөл боловсруулах	Хууль хэрэгжсэн байх	2019 оны төсвийн төслийг маягтын дагуу боловсруулж 2018 оны 07-сарын 06-нд хүлээлгэн өгсөн.	100%
10	Давсан орлогыг зарцуулах төлөвлөгөө гарган ИТХ-д оруулан батлуулж хэрэгжүүлэн ажиллах		Орон нутгийн давсан орлогыг 2018.12.18-ны өдрийн ИТХ-ын хуралдаанд танилцуулахад бэлэн болгоод байна.	70%
11	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гарган нийтэд мэдээлэх	Ил тод байдал хангагдсан байх	2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг гарган “Цагаандэлгэрийн мэдээ” цахим хуудас болон ЗДТГазрын мэдээллийн самбарт байршуулан ажиллалаа.	100%
12	Төсвийн байгууллагын санхүүгийн баримт болон ОНХС-ийн тендэрийн баримт бичиг боловсруулахад мэргэжил арга зүйн тусламж үзүүлэх,	Алдаа зөрчил гараагүй байх хууль хэрэгжсэн байх	Сангийн сайдын 290 тушаалаар батлагдсан журмын дагуу бүрдүүлэх материалыг шалган тендэрийн гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.	70%

	төндэрийн гүйцэтгэлд хяналт тавих, тайлагнах			
13	Эд хөрөнгийн тооллого зохион байгуулж үр дүнг тооцох, балансад бүртгэх, тайлагнах, нийтийн ерөнхий үйлчилгээний эд хөрөнгөд хаягжуулалт хийх	Тооллого явуулж үр дүнд хүрсэн байх	2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн А/12 тоот тушаалаар эд хөрөнгийн тооллого зохион байгуулж эзэмшиж буй хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг шалган эзэмшигчийн карт хөтлүүлж, эд хөрөнгөд кодлолт хийсэн. Жилийн эцсийн тооллогыг 12 сарын 01-ээс эхлэн зохион байгуулж албан байгууллагуудаас Сумын өмч хамгаалах байнгын зөвлөл шинээр орлогодох болон актлаж устгах хөрөнгийн жагсаалттай танилцан холбогдох байгууллагуудад танилцуулсан.	70%
14	2017 оны санхүүгийн тайланг гаргаж аудитаар оруулж тайлагнах, дүнг нийтэд мэдээлэх	Санхүүгийн сахилга бат дээшилсэн байх	2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2018 оны 03 сарын 03-17 хооронд аудитаар оруулж баталгаажуулан дүгнэлт гаргуулсан. Аймгийн төрийн санд аудитлагдсан тайланг хүлээлгэн өгч санхүүжилтийн тооцоо нийлсэн. Сумын хэмжээнд нийт 6 төсөвт байгууллага СХС, ОНХСан бусад төсөл сангууд хамрагдсан. Төрийн аудитын байгууллагаас нийт 24,258,525 төгрөгний зөвлөмж 44,475,922.20 төгрөгний хариуцлага тооцох санал 23,550,700 төгрөгний албан шаардлага 4,000,000 төгрөгний залруулга хийгдэж сумын нэгтгэлийн дүнгээр залруулагдаагүй 47,8 сая төгрөгний зөрчил илэрч “Хязгаарлалтай” санал дүгнэлт өгсөн. Төрийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу нэгтгэсэн тайлангийн дүгнэлтийг байгууллагын дарга нарын хуралд танилцуулан Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж цаашид авах арга хэмжээний талаар төлөвлөгөө гарган ажиллаж байна. Дүгнэлтийг мэдээллийн самбар болон Шилэн дансанд байршуулсан. Хугацаатай зөвлөмжийн хариуг 100% өгсөн.	100%
15	Орон нутгийн орлогыг бүрдүүлэх ажлыг чанартай зохион байгуулж үр дүнд хүрэх	Төлөвлөгөө биелсэн байх	Орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх талаар дараах ажлыг зохион байгуулан ажилласан байна. Үүнд татвар төлөгч иргэн, ААНБайгууллагуудад тухайн оны татвараа цаг хугацаанд нь төлөх талаар нэхэмжлэх 36, мэдэгдэх хуудас 124-ийг тарааж ажилласан. Мөн бууны албан татвар болон хог, газрын төлбөрийг төлөх талаар иргэдтэй нэг бүрчлэн утсаар ярих, багийн дарга нараар дамжуулан мэдэгдэх хуудас өгөх, татвар, татвар төлөлтийн талаарх мэдээллийг багийн иргэдийн хурал, татвар төлөгчдийн өдөр, нээлттэй хаалганы өдөрлөг зэргээр иргэдэд сурталчлан таниулах, гарын авлага, тараах материал өгөх зэргээр ажиллаж ирсэн. Ингэснээр татварын орлогын төлөвлөгөө 9 сарын байдлаар 241 хувьтай биелээд байна. Тухайлбал: Төлөвлөгөө болон биелэлт 2018 оны 9 сарын байдлаар өссөн дүнгээр ИОТ-4900,0 төгрөг төвлөрөхөөс 3866,0 төг орж 78 хувьтай, хадгаламжийн хүүгийн орлого 4020,0 төг төвлөрөхөөс 4388,4 төг	100%

			орж 109 хувьтай, бууны орлого 844.8 төг төвлөрөхөөс 810.0 орж 96 хувьтай, УТХураамж 920,0 төвлөрөхөөс 1260,4 орж 137 хувьтай, хогны төлбөр 974.4 төвлөрөхөөс 365.0 орж 37 хувьтай, хүү торгуулийн орлого 1010.0 төвлөрөхөөс 1842,8 орж 182 хувьтай, төсвийн өөрийн орлого 210.0 төвлөрөхөөс 0 орж 0 хувьтай, түгээмэл тархац 236,9 төвлөрөхөөс 0 орж 0 хувьтай, ангийн орлого 19,200,0 орж 100 хувьтай, бусад орлого 42,9 орохоос 21,0 орж 49 хувьтай тус тус эхний 9 сарын байдлаар төвлөрч орон нутгийн орлого 241 хувьтай биелээд байна.	
16	Сумын хэмжээнд татварын багц хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж татварын төлөвлөгөөг төрөл тус бүрээр сар, улирал, жилээр жигд ханган биелүүлэх	Төлөвлөгөө биелсэн байх	Сумын хэмжээнд татварын багц хуулиар 156 иргэнд сургалт сурталчилгааг хийсэн байна. Тухайлбал татвар төлөгчдийн өдрүүд, багийн өдөрлөг, нээлттэй хаалганы өдөрлөг, автын үзлэгийн үеэр 260 ширхэг гарын авлага тараах материал тарааж, цахимаар болон өөрийн биеэр мэдээлэл хүргэх, 156 иргэнд сургалт зохион байгуулсан байна. Татварын төлөвлөгөөг жигд ханган, төрөл тус бүрээр сар, улирлаар биелүүлэн ажиллахын тулд татвар төлөгч иргэн, ААНБайгууллагуудад тухайн оны татвараа цаг хугацаанд нь төлөх талаар нэхэмжлэх 36 ширхэг, мэдэгдэх хуудас 124 ширхэгийг тарааж ажилласан. Татварын орлогын төлөвлөгөө 2018 оны 9 сарын байдлаар өссөн дүнгээр орон нутгийн орлого 241 хувьтай биелээд байна, Нийт дүнгээр болон зарим төрөл дээр биелээд байгаа боловч төсвийн өөрийн орлого, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн татварууд 0 хувьтай биелээгүй явж байна. ТӨОрлогын хувьд жилийн эцэст бөөн дүнгээр биелэгддэг.	100%
17	Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах	Хугацаандаа төлөгдсөн байх	Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын дагуу "Сум хөгжүүлэх сан"-гийн журмын хэрэгжилт үйл ажиллагаанд Хяналтын зөвлөлийн дарга Г.Дэмбэрэлжав, нарийн бичгийн дарга Ж.Чулуунтогтох нарын хамт 1 удаа шалгалт хийж зээл, зээлийн хүү төлөх талаар хугацаатай албан мэдэгдэл хүн тус бүрт хүргэн гарын үсэг зуруулан хүлээлгэн өгч ажиллалаа. Мөн сар тутам зээлдэгч нартай 2-оос доошгүй удаа утсаар ярьж анхааруулан ажиллаж байна. Хяналт шалгалтын арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд 13 иргэн, 2 ААН-ийн үндсэн зээл 26.016.725 төгрөг, зээлийн хүү 2.603.341 төгрөг бүгд 28.620.066 төгрөгийг "Сум хөгжүүлэх сан"-д төвлөрүүлэн ажилласан. Одоогийн байдлаар зээл хэрэгжүүлж байгаа 15 иргэн үйл ажиллагаа явуулж байгаагаас 2013-2014 онд зээлд хамрагдсан 4 иргэн, зээл хэрэгжүүлэх хугацаа дуусаж үндсэн зээл 18.130.688 төгрөг, зээлийн хүү 1.568.162 төгрөг бүгд 19.698.850 төгрөгийн буцаан төлөлт хэтэрсэн байна. Одоогоор СХС-д 15 иргэний зээл хэрэгжиж байгаагаас гадна 5 иргэн зээл,	90%

			зээлийн хүүгээ бүрэн төлөн хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна. Сум хөгжүүлэх санд 2018 оны 12 сарын 1-ны байдлаар 43.518.758 төгрөг төвлөрсөн байна. Сум хөгжүүлэх сангаас программ шинэчлэн суулгасны төлбөрт 750.000 төгрөг, шуудан холбоонд 120.000 төгрөг, бичиг хэргийн зардалд 90.000 төгрөг буюу 960.000 төгрөгийн зардал гарч дансны үлпэгдэл 133.112.520 төгрөг байна.	
18	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангах	Төлөвлөгөө биелсэн байх	НД-ын шимтгэлийн орлого 69,689.5 мянган төгрөгийн шимтгэлийн орлого оруулж төлөвлөгөөг биелүүлсэн.	100%
19	Шимтгэлийн өр авлага үүсгэхгүй байх	Өр авлага үүсээгүй байх	НДШимтгэл төлөгч байгууллагуудаас НД-7.8 тайланг сар бүр батлагдсан маягтуудын дагуу авч мэдээллийн санг бүрдүүлэн хэлтэст хүргүүлэн шимтгэлийн өр авлагагүй ажиллаж байна.	100%
Дөрөв. Байгаль орчин, газар зохион байгуулалтын ажлын хүрээнд				
1.	Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр иргэдэд газраа өмчилж авах талаарх хуулийн сурталчилгааг хийж, газар өмчилж авах газрын ач тусын талаарх сургалтыг зохион байгуулах	Иргэд мэдээ мэдээлээр хангагдаж хууль хэрэгжсэн байх	9-р сард зохион байгуулагдсан багуудын хуралд газрын даамал оролцож гэр бүлийн хэрэгцээний зохиулалтаар шинээр газар өмчилж авах талаар сургалт мэдээллийг хийж нийт 316 иргэн хамрагдсан. 2018 оны 04 сарын 18-нд нээлттэй хаалганы өдөрлөгөөр газар өмчлөлийн талаар гарын авлага, боршурыг тарааж 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу олгох газрын байршлийг танилцуулсан. 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу Засаг даргын захирамжаар нийт 63 иргэн гэр бүлийн хэрэгцээний газраа кадастр хийлгүүлэн авсан.	100%
2	Бэлчээр, тариалангийн талбайд тархсан хортон мэрэгчидтэй тэмцэх ажлыг малчид иргэдийн оролцоотойгоор хийж ажлыг зохион байгуулах	Үр дүнд хүрсэн байх	Тус сумын нутаг дэвсгэрт хөнөөл ихээр учруулж байгаа үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг эрчимжүүлэх үүднээс ХХҮГазарт “Үлийн цагаан оготно устгах” төсөл бичин нийтийг хамарсан ажилд 10-н ажил эрхэлдэггүй иргэнийг хамруулан түр ажлын байраар ханган ажиллалаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А-31 дугаар тушаал,Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн А/203 дугаар захирамжийг хэрэгжүүлэн 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдөр аймгийн ХХААГазрын даргатай байгуулсан гэрээний дагуу сумын Засаг даргын 2018 оны 05 дүгээр сарын 07-ний өдрийн А/40 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд үлийн цагаан оготно тархсан талбайд тандалтыг нарийвчлан хийж байршлыг тогтоон хортон мэрэгчтэй тэмцэх талбайг сонгон 1-р багийн нутагт Хар цав, Ар шанд, Хөх эрэг, Хадат ам, Ар могой, Хараат, Нарийн ус, Хөх ус, 2-р багийн нутагт Өвөр могой, Улаан хошуу, Зүлэгт, Хөх өндөр, 3-р	100%

			багийн нутаг Сайн шанд Хашаат, Аман ус, 4-р багийн нутаг Чулуут цагаан, Шорвог, Элгэн, Хөх өндөр зэрэг газруудад 5000 га талбайд 2018 оны 05 дугаар сарын 07-ний өдрөөс эхлэн 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдөр хүртэл 10 хоногт багтаан хийж гүйцэтгэсэн байна. Бэлчээрийн үлийн цагаан оготной тэмцэх ажилыг 17000 га талбайд малчдыг оролцуулж микробиологийн аргаар 8050000 төгрөгийн 2.2 тн бактержуулсан будааг малчдын өвөлжөө, хаваржааны орчимд цацлаа. Мөн утах төхөөрөмжөөр 4 мотоциколь, 10 хүн 10 хоногийн хугацаанд утаж үр дүнгээ өгч байна. 3-р улиралд 10 сая төгрөгөөр малчдыг дайчлан утах, хавх тавих, наалддаг хор тавих зэрэг арга ашиглан бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготной тэмцэх ажил зохион байгуулсан.	
3	2018 онд газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг 2017 оны 12 сарын 20-ны өдөр сумын ИТХ-аар батлуулж төлөвлөгөөний дагуу газар өмчлөлийн ажлыг 2018 оны 04 сарын 25-нд зохион байгуулж нийт 63 иргэн дээр газар өмчлөлийн Засаг даргын захирамжийг гаргалаа.	100%
4	Батлагдсан газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу иргэнд газар өмчлүүлэх ажлыг зохион байгуулах	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг 2017 оны 12 сарын 20-ны өдөр сумын ИТХурлаар батлуулж төлөвлөгөөний дагуу газар өмчлөлийн ажлыг 2018 оны 04 сарын 25-нд зохион байгуулж нийт 63 иргэн дээр газар өмчлөлийн Засаг даргын захирамжийг гаргалаа	100%
5	Сумын хэмжээний хүн амын ундны усны чанар аюулгүй байдлыг хангах хяналт шалгалт хийх	Ундны усны аюулгүй байдал хангагдсан байх	2018 оны 03 сарын 12-нд аймгийн мэргэжлийн хяналтын байгууллагад сумын төвийн ундны 2 худагын усны дээжийг өгч явуулсан.	70%
6	Ерөнхийлөгчийн зарлигаар бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулах	Ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байх	Ногоон зурвас байгуулах ажлын хүрээнд 2018 оны 05 сарын 02-нд аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас 200 улиас, 200 хайлаас, 100 шар хуайс, 100 агч модыг авчирч тарьсан байна. Мөн сумын хэмжээнд үхрийн нүд, шар хуайс зэрэг нийт 680 мод тарьлаа. 2018 оны 05 сарын 21-нд Ц.Мөнгөнчимэгтэй мод услах гэрээ хийж усалгааг тогтмол хийж ажиласан.	100%
7	Бүх нийтийн цэвэрлэгээг хийж ААНБ, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх хамтран ажиллах	Хоггүй орчин бүрдсэн байх	Сумын засаг даргын 2018 оны 04 сарын 27-ны А/38 тоот захирамжийн дагуу Цэмцгэр Цагаандэлгэр-2 уриатайгаар нийтийн цэвэрлэгээний ажлын хэсэг байгуулагдаж ажлын төлөвлөгөө гаргаж албан байгууллага аж ахуй нэгжүүд, иргэдэд албан мэдэгдлийг тарааж 2018 оны 05 сарын 18,19 –нд 2 өдөр зохион байгууллаа. 05 сарын 18 албан байгууллага аж ахуй нэгж ойр орчимдоо сумаас гарч байгаа төв замуудыг хуваана авч, иргэд	100%

			өөрийн эзэмшлийн хашааны ойр орчмыг цэвэрлэлээ. 05 сарын 19-нд сумын төвийг 3 хэсэг болгон хувааж нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэж нийт 4 машин ажиллаж нийт 48.5 тн хогийг ачиж хогийн цэгт хаялаа. Намрын нийтийн их цэвэрлэгээг Дундговь аймгийн засаг даргын А/446 дугаар захирамж, Эрүүл мэндийг дэмжих жилийн 3.1.2 дугаар заалтын дагуу Цагаандэлгэр сумын нийт албан байгууллага, ААН, айл өрхүүд 10-р сарын 19,20-ний өдрүүдэд сумаас гарч буй замууд болон сумын төвийн хогийг цэвэрлэсэн. Хог хаягдлын орон нутгийн орлого оруулах тал дээр анхаарч ажиллан 644,000 мянган төгрөг төвлөрүүлсэн байна. Золбин нохой, муур устгах ажлыг зохион байгуулж 18 нохой, 61 муур устгасан байна.	
8	Өвлийн цасны явуул судалгааг тогтсон цэгт хийх	Өвөлжилтийн судалгаа гарна.	Өвлийн цасны явуул судалгааг 2018 оны 01 сарын 18-ны өдөр хийж тогтсон цэг болох 1-р багт Хув ус, 2-р багт Номт, 3-р багт Хашаат, 4-р багт Шар шороот гэх газруудад хийж 204 км явж судалгааг хийсэн. Тухайн цэгийн ойролцоох цасны бүрхэц балл, цасны дундаж өндөр, цасны хамгийн өндөр хунгарын зузаан, хөрийн зузаан, цасны нягтыг хэмжиж гаргасан. Тухайн цэгийн ойролцоох ургамлын идэгдэлтийн байдал, цаснаас дээшхи ургамлын өндөр, цасны дор мөсөн үе тогтсон эсэхийг тус тус хэмжиж судалгааг хийсэн.	100%
9	Байгаль орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар эргүүл хяналт шалгалтыг тогтмол хийх	Хэрэг зөрчил бага гарч хяналт хариуцлага сайжирна	Сумаас баруун урагш 1-р багийн нутаг болох Сүмийн дөрвөлж нэртэй газарт Байгалийн өнгөт чулуу түүх зөрчил гарсан ба 3 удаа дуудлага ирж хэсгийн төлөөлөгч Т.Адъяабат, байгаль орчны байцаагч Г.Уранбилэгийн хамт очиж ажилласан. Байгаль орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл хяналт шалгалтыг тогтмол хийж байна.	70%
10	Иргэдийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг хангаж тэжээвэр нохойг гэрчилгээжүүлж, туулгалт, вакцинд хамруулах, золбин нохой устгах	Ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байх	Тэжээвэр нохой гэрчилгээжүүлэх ажил 2017 онд зохион байгуулагдсан. Золбин нохой устгуулах талаар зар тавьж сумын төвийн иргэдэд сонор сэрэмжтэй байх, нохойгоо байнгын уяатай байлгах талаар үүрэг чиглэл өгч, нохой эзэмших ашиглах журмын айл өрхүүдэд тарааж багийн Засаг дарга нараар дамжуулан	100%

			анхаарал болгоомжтой байхыг байнга сануулж ажилласан. Айлын малд орсон 5 нохойг устгасан байна. Золбин нохой устгах судалгааг гаргаж 12 сард иргэн Г.Чинзоригтоь гэрээ байгуулан 18 нохой, 61 муур устгаж 790,000 төгрөг зарцуулсан.	
Тав. Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн ажлын хүрээнд				
1	Мал сүргийг гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх эрүүлжүүлэх ажлыг цаг хугацаанд нь шуурхай зохион байгуулж, өвчнөөр тайван нөхцлийг хангана.	Халдварт өвчин гарахгүй байх	2017 оны 12-р сарын 29-ний өдөр тус сумын нутаг үхэр, хонинд малын гоц халдварт Шүлхий өвчний шинж, тэмдэг малаас дээж авч Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторид явуулж Улсын мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн 2018 оны 01-р сарын 03-ны өдөр шинжилгээний хариугаар халдварт Шүлхий өвчин болох нь тогтоогдсон. Сумын Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дугаар захирамжаар хорио цээрийн дэлглэм тогтоогоож ҮХАА-н сайдын 2014 оны 08 дугаар сарын 28ны өдрийн А/93 дугаар тушаалаар батлагдсан “МАЛ, АМЬТНЫ ШҮЛХИЙ ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ ЗААВАР”-ыг баримтлан ажилласан. Мал устгалын цэгийг 4-р багийн нутаг “Цагаандайн ухаа” гэдэг газарт байгуулсан. Сумын Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/05 дугаар захирамжаар устгалын комисс томилогдож 8 удаа устгалын цэгт ажиллаж 24 өрхийн 46 үхэр, 11 хонь, 7 ямаа нийт 64 өвчний шинж тэмдэг илэрсэн малын устгалын цэт устгах арга эмжээ авч нөхөн олговор олгоход шаардагдах баримт бичиг, актуудыг хууль, журмын дагуу үйлдсэн. Мөн үхсэн малын сэг зэм болон 88 үхсэн зээрийг устгалын цэгт булсан. Шүлхий өвчний шинж тэмдэг нэмэгдэж илрээгүй тул Засаг даргын 2018 оны 02-р сарын 12-ны өдрийн А/17 дугаар захирамжаар хязгаарлалтын дэглэмийг цуцласан. Вакцинжуулалтын хувьд 4650 үхэрт давтан тарилтаар 2 удаа, 362 тэмээ, эрүүл бүсийн 11288 хонь, 8810 ямаа нийт 25110 малын урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан байна. 3-р улиралд 3326 үхрийг вакцинд хамруулсан.	100%
2	Ноос, арьс ширний урамшууллыг журмын дагуу материалыг бүрдүүлж бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	Урамшуулал бүгд олгогдсон байх	Арьс, ширний урамшуулалд хамрагдахаар 32 өрхийн хонины арьс 972, ямааны арьс 281, адууны арьс 3, үхрийн шир 46 нийт 1302ш арьсыг бэлтгэн нийлүүлээд байна. Мөн 2017 оны ноосны урамшуулалд 90 малчин, мал бүхий өрхийн 25.1 сая төгрөгийн урамшуулал авсан байна. 2018 оны ноосны урамшуулалд 156 малчин, мал бүхий өрхийн хонины ноос 49859.9 кг, тэмээний ноос 849.3 кг нийт 50709.2 кг ноосыг урамшуулалд хамруулахаар материалыг аймгийн ХХААГазарт өгсөн байна.	90%

3	Мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах	Үр дүн гарсан байх	“Цаст ундарга” мал эмнэлгийн бичиг байгаа малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавин ажиллаж байна.	100%
4	Малын өвс тэжээл бэлтгэх, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлэх, өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах	Өвөлжилтийн бэлтгэлийг хангах өвс тэжээлийн бүрдүүлсэн байх	8 сая төгрөгийн хөрөнгөөр “Хамтын хүч” бүлэгтэй хамтран хуучин дизель станцын байр, хуучин нөөцийн агуулахын төмөр матеиалыг ашиглан нөөцийн агуулахыг бариад байна. Мөн аюулгүйн нөөцөд ЗГ-ын тогтоолын дагуу 28.3 тн өвс, 11.8 тн тэжээлийн нөөцийг бүрдүүлээд байна. 	100%
5	“Малчдын зөвлөгөөн-ийг зохион байгуулах	Малчдад хууль тогтоомжийг сурталчлан таниулах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх	3-р сарын 8-9-ний өдрүүдэд “Таван эрдэнэ” малчдын зөвлөгөөнийг “Малчдаа сонсьё” уриан дор зохион байгуулж зөвлөгөөнийг “Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв”-ийн “Инвест Кооп Монгол” төслөөс 2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүллээ. Уг зөвлөгөөнөөр Мал аж ахуй дээр тогтвортой ажиллаж байгаа залуу малчин А.Сэрээтэрийг Аймгийн аврага малчин Д.Сайнбаяр 5 эм хонь, Б.Бүдхандыг сумын аварга малчин Т.Арсланбаатар 5 эм хонь, О.Цэрэнсодномыг сумын аварга малчин Д.Түвдэнням 10 эм хонь, 10 эм ямаагаар тус тус ивээн тэтгэж “ИЛТЭЭЛТИЙН ЭЗЭН”-ий үнэмлэх гардууллаа. Мөн Сум орон нутагтаа мал аж ахуй дээр тогтвортой ажиллаж амьдарч байгаа шилдэг залуу малчнаар шалгарсан М.Сумъяадорж, А.Цогтбаатар, Д.Мөнхбаатар, Х.Цэдэгсүрэн нарт шагнал гардууллаа. 6-р сарын 15-16-нд багуудын нэгдсэн өдөрлөгийг зохион байгуулж өдөрлөгөөр ахмадын “Спортын бага наадам”-ыг зохион байгуулж ахмадын дунд спортын 7 төрлөөр тэмцээн зохион байгууллаа. Мөн аймгийн ТХДЖТеатрын уран бүтээлчдийг урьж хүндэтгэлийн тоглолт хийлээ.	100%

6	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд төлөвлөгөөт мал сүргийг бүрэн хамруулах	Мал сүрэг бүрэн хамрагдсан байх	Малын гоц халдварт Шүлхий өвчин гарсны улмаас 4650 үхэрт давтан тарилтаар 2 удаа, 362 тэмээ, эрүүл бүсийн 11288 хонь, 8810 ямаа нийт 25110 малын урьдчилан сэргийлэх вакцинд хамруулсан байна. Шөвөг яраас сэргийлэх вакциныг 79 өрхийн хурга 7078, ишиг 11344 нийт 18422 төлд хийгээд байна. Цусан халдвартын вакцинд 7934 бог, Дотрын халдварт хордлогын вакцинд 8096 бог мал, Сахуугаас сэргийлэх вакцин 669 унага, Дуут хавдараас сэргийлэх вакцин 200 үхэр, Галзуугаас сэргийлэх вакцин 200 үхэр, Шүлхийн вакцин 3326 үхэрт, Бруцеллёзын вакцинд тугал 231, хурга, ишиг 31672 төл хамруулсан байна. Туулгалтанд хонь 8750, ямаа 3636, угаалга 13580 мал угаалганд хамруулсан.	100%
7	Дундговь түншлэл арга хэмжээнд зохион байгуулалттай оролцох	Иргэдийн орлого нэмэгдэж ажлын уялдаа сайжирна.	Дундговь түншлэл-2018 арга хэмжээнд идэвхтэй оролцон 4-р багийн иргэн А.Эрдэнэчимэг, П.Сугирсүрэн нар хөхүүр, суран эдлэл, 2-р багийн малчин Х.Цэдэгсүрэн, Б.Батбаяр, Н.Алтанхуяг, Д.Мягмардорж нар айргаар үзэсгэлэн худалдаанд оролцов. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан үйл ажиллагаанд идэвх санаачлага, зохион байгуулалттай оролцсон 5 сумын нэгээр шалгарч талархал хүлээн авсан амжилт гаргалаа.	100%
8	Зээл төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголтын талаар ил тод нээлттэй ажиллах, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах	Ил тод мэдээ мэдээллээр иргэдийг хангасан байх	СХС-аас зээл авсан иргэдийн талаарх судалгааг мэдээллийн самбарт байршуулсан. Зээл авсан болон хуучин зээлийн үлдэгдэлтэй иргэдийн зээл төлж дуусах хугацаанд дахин зээл олгохгүй байх бодлого барин ажиллаж байна. СХС болон хөдөлмөр эрхлэлтийн жижиг зээл, төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийн багуудын хула, мэдээллийн самбар, мэдээллийн цагаар тогтмол хүргэж ажиллаж байна.	100%
9	Сум хөгжүүлэх сангийн зээлийг үр ашигтай зарцуулж эргэн төлөлтөнд хяналт тавьж, үр дүнд хүргэх	Зээлийн үр ашиг нэмэгдэж ажлын байр нэмэгдсэн байх	Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын дагуу "Сум хөгжүүлэх сан"-гийн журмын хэрэгжилт үйл ажиллагаанд Хяналтын зөвлөлийн дарга Г.Дэмбэрэлжав, нарийн бичгийн дарга Ж.Чулуунтогтох нарын хамт 1 удаа шалгалт хийж зээл, зээлийн хүү төлөх талаар хугацаатай албан мэдэгдэл хүн тус бүрт хүргэн гарын үсэг зуруулан хүлээлгэн өгч ажиллалаа. Мөн сар тутам зээлдэгч нартай 2-оос доошгүй удаа утсаар ярьж анхааруулан ажиллаж байна. Хяналт шалгалтын арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд 13 иргэн, 2 ААН-ийн үндсэн зээл 26.016.725 төгрөг, зээлийн хүү 2.603.341 төгрөг бүгд 28.620.066 төгрөгийг "Сум хөгжүүлэх сан"-д төвлөрүүлэн ажилласан. Одоогоор СХС-д 15 иргэний зээл хэрэгжиж байгаагаас гадна 5 иргэн зээл, зээлийн хүүгээ бүрэн төлөн хэвийн үйл ажиллагаагаа явуулж байна. 2018 оны 12 сарын 1-ны байдлаар Сум хөгжүүлэх санд 43.518.758	90%

			төгрөг төвлөрсөн байна. Сум хөгжүүлэх сангаас программ шинэчлэн суулгасны төлбөрт 750.000 төгрөг, шуудан холбоонд 120.000 төгрөг, бичиг хэргийн зардалд 90.000 төгрөг буюу 960.000 төгрөгийн зардал гарч дансны үлдэгдэл 133.112.520 төгрөг байна. 2017 онд Аuidтын байгууллагаас сум хөгжүүлэх сангийн өр авлага 75134256 төгрөгийн акт тавигдснаас хугацаа хэтрэлттэй өр авлага 52314341 төгрөгийн өр барагдуулан ажиллаж, үлдэгдэл 22819915 төгрөгийн хэтрэлт байгаагаас шүүхэд 2 иргэний 11634250 төгрөгийн өрийг барагдуулахаар явуулсан байна. Одоо зээлийн хэтрэлт 11185665 төгрөгийн өртэй байна. Өр барагдуулалт 85,1 хувь байна.	
Зургаа. Нийгмийн бодлогын хүрээнд				
1.	Албан хаагчдыг ажлын байран дээр нь дасгал хөдөлгөөн хийлгэж хэвшүүлэх	Жигдэрсэн байх	ТГ-ын ажилчдад ажлын байрны дасгал хөдөлгөөнийг зааж өдөр бүр 11 цагт хийлгэж хэвшүүлж байна.	70%
2.	Албан хаагчдын бие бялдрын хөгжлийн чийрэгжилтийн түвшин тогтоох сорил явуулах	Сорил явуулсан байх	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны “Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх тухай 53 дугаар зарлигийн хэрэгжилтийг хангах зорилгоор хүн амын бие бялдарын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд байгууллагын 20 ажилчдыг хамруулсан.	100%
3.	Хүүхдийн чуулган зохион байгуулах	Үйл ажиллагаа зохион байгуулж үр дүнд хүрэх	“Инээж буй хүүхэд” нэртэй хүүхдийн анхдугаар чуулганыг 2018 оны 5 сарын 16-нд амжилттай зохион байгуулж нийт 140 хүүхэд хамрагдсан. Чуулганы үеэр хүүхэд хамгааллын хамтарсан багийн 2017 онд хийж хэрэгжүүлсэн ажил, 2018 онд хийхээр төлөвлөсөн ажлаа танилцууллаа. Мөн хүүхэд хамгааллын хамтарсан баг болон багийн гишүүдийн үүрэг хариуцлагын талаар мэдээлэл хийсэн.	100%
4.	“Залуучуудын чуулган” зохион байгуулах	Үйл ажиллагаа зохион байгуулж үр дүнд хүрэх	Хэрэгжээгүй	0%
5.	Нийгмийн шинж чанартай үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд байнга хяналт тавьж тэдгээрийг хэрэгжүүлэх тусгай төлөвлөгөө гарган биелэлтийг ИТХ, Засаг даргын зөвлөлд танилцуулж байх	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	Нийгмийн хүрээний чиглэлийн үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт тавьж 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг холбогдох мэргэжилтэн байгууллагуудаас авч хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тооцож ажилласан.	70%

6	“Сумын аварга” шалгаруулах спортын олон төрөлт тэмцээнийг зохион байгуулах	Үйл ажиллагаа зохион байгуулж үр дүнд хүрэх	Сумын Засаг даргын 2018 оны 7 сарын 19 ны өдрийн А/62 тоот захирамжийн дагуу сумын биеийн тамир спортын орон тооны бус зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Монгол Улсын Ерөнхий Сайдын ивээл дор зохион байгуулагдаж буй “Иргэдийн спортын наадам”-ын сумын аварга шалгаруулах спортын наадмыг 2018 оны 10 сарын 04-ний өдөр олс таталт, гар бөмбөг, ойрын зайн кросс гүйлт, сагсан бөмбөг, хөл бөмбөг гэсэн 5 төрлөөр зохион байгуулж 120 гаруй иргэд хамрагдсан. Шалгарсан тамирчид 10 сарын 05-07 ны хооронд Дундговь аймагт зохион байгуулагдсан аймгийн шигшээ наадамд гар бөмбөгийн төрөлд амжилттай оролцсон.	100%
7	Морин аялал, явган аялал зохион байгуулах	Аялал зохион байгуулсан байх	2018.10.05-07-ны өдрүүдэд Мандалговь хотноо зохион байгуулагдсан "Тогтвортой мал аж ахуй -2018" залуу малчдын зөвлөгөөн, "Морьтны соёл - Айрагны баяр" арга хэмжээнд сумын удирдлага, багийн дарга нар, залуу малчид зэрэг 24 хүний бүрэлдэхүүнтэй оролцож дууны төрөлд И.Жаргалбат 2-р байр, сайхан хос морьтны төрөлд С.Батбаяр, И.Жаргалбат нар 3-р байр эзэлж, идэвхи санаачлага гаргаж бэлтгэл зохион байгуулалттай оролцсон сумаар шалгарлаа. “Нутаг усаараа бахархaya” явган аялалыг 2018 оны 11 дугаар сарын 07-ны өдөр төрийн албан хаагчдын дунд амжилттай зохион байгуулсан. Тус уралдаанд нийт 6 байгууллагын 42 албан хаагч оролцож, олс таталтын төрөлд 1-р байранд хүүхдийн цэцэрлэг, морин байлдаан төрөлд 1-р байранд жижиг байгууллагууд, сумо эрэгтэй төрөлд хүүхдийн цэцэрлэгийн жижүүр Баасансүрэн, эмэгтэй төрөлд ЭМТөвийн сувилагч Бямбажаргал, уулын оргил булаалдах төрөлд жижиг дунд байгууллагууд тус тус тэргүүн байрыг эзэллээ. Явган аялалын маршрутыг сумын төвд байрлах “Ембүү овооноос – сумын тахилгат Хараат” уул хүртэл үргэлжилсэн юм.	100%
8	Зүүн бүсийн үндэсний бөхийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	Үйл ажиллагаа зохион байгуулж үр дүнд хүрэх	Дундговь аймгийн зүүн бүсийн үндэсний бөхийн аварга шалгаруулах цолгүй залуу бөхчүүд болон сумын заан цолтой бөхчүүдийн барилдаанд нийт 5 сумын 40 гаруй бөх барилдаж Гурвансайхан сумын харъяат сумын заан Б.Дашдамба 1-р байр эзэлж Дэрэн сумын харъяат залуу бөх Т.Уугантулга 2-р байр, Баянжаргалан сумын харъяат сумын заан Дашням, Гурвансайхан сумын харъяат сумын заан Бямбадорж нар тус бүр 3,4 -р байр эзэллээ. Дээрх барилдааныг Сумын Засаг даргын тамгын газар, Бөхийн холбоо нар хамтран зохион байгуулж бөхийн холбооны тэргүүн Аймгийн нэмэх начин Б.Төмөрбат ивээн тэтгэлээ.Мөн барилдааны хаалтын барилдаанд Аймаг сумын цолтой 26 бөх барилдаж Аймгийн арслан Б.Гончигтавхай түрүүлж Аймгийн	100%

			арслан Э.Мөнхбаатар үзүүрлэж Аймгийн заан Н.Наранбаатар шөвгөрлөө. Дээрх барилдааныг 1-р багийн харъяат мянгат малчин Х.Мөнхбат ивээн тэтгэж байллаа.	
9	Гэр бүл, хүүхэд, ахмад, залуучуудад чиглэсэн төрөл бүрийн уралдаан тэмцээн, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Үйл ажиллагаа зохион байгуулж үр дүнд хүрэх	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр хамтарч цэцэрлэгийн бага, ахлах бүлэг, сургуулийн 1-4-р ангийн хүүхдүүдийн дунд “Миний бүтээл” сэдэвт уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж шалгарсан хүүхдүүдийг өргөмжлөл, бэлэг, дурсгалын зүйлээр шагнасан. 2018 оны 6 сарын 15-16 ны өдрүүдэд 4 багийн өдөрлөгөөр ахмадын спортын бага наадмын анхан шатны тэмцээнийг 5 төрлөөр сумандаа зохион байгуулсан. “Ахмадын спортын бага наадам”-д шалгарсан 13 ахмад тамирчдыг бэлтгэн оролцуулсан. 10 сарын 04-нд Монгол улсын ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулагдсан “Иргэдийн спортын наадам”-ын сумын аварга шалгаруулах уралдааныг ЗДТГазар, Соёлын төвтэй хамтран спортын 5 төрлөөр зохион байгуулж шалгарсан тамирчдыг Дундговь аймагт зохион байгуулагдсан “Иргэдийн спортын наадам”-ын шигшээ тэмцээнд оролцуулсан.	90%
10	ЗГ-ын 2014 оны 71-р тогтоолын дагуу дээд боловсролын байгууллагад суралцагдах сургалтын тэтгэлэг олгоход дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	Ажил зохион байгуулсан байх	ЗГ-ын 2014 оны 71-р тогтоолын дагуу дээд боловсролын байгууллагад суралцагчдын сургалтын тэтгэлэгт хамрагдахаар нэг оюутан саналаа ирүүлсэн боловч шалгуур үзүүлэлтийг хангаагүй учир тэтгэлэгт хамрагдаж чадаагүй.	100%
11	Ажилтан албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах	Үзлэг шинжилгээнд хамруулсан байх	Төрийн албан хаагчдыг 2018 оны 6 сарын 6-ны өдөр аймгийн нэгдсэн эмнэлгийн явуулын амбулаторын үйлчилгээнд дотор, мэдрэл, ЭХО, эмэгтэйчүүдийн нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээнд хамруулж нийт албан хаагчдын 75%-ыг хамруулсан. Элэгний В С вирусын илрүүлэг үзлэг шинжилгээ, хөх умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд зорилтот насны албан хаагчдыг бүрэн хамруулж ажилласан.	100%
12	Сүрьеэ, ДОХ-той тэмцэх өдрөөр үйл ажиллагаа зохион байгуулах	Ажил зохион байгуулсан байх	2018.10.18нд Сүрьеэгийн илрүүлэг үзлэгийг Дундговь аймгийн Говь-Угтаал суманд ажиллах явуулын амбулаторитой хамтарч явуулахаар төлөвлөөд байна. ХБ-өөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд зонхилон тохиолдох ХӨ-ний өвчлөлийн тархалтыг бууруулах зорилгоор сэргэн мандаж буй 3 төрлийн сэдвээр 1 удаагийн сургалтыг хийж 125 хүнийг хамруулж хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд заавал хийх дархлаажуулалтанд хүүхдийг 100% хамруулаад байна. Дэлхийн сүрьеэтэй тэмцэх өдөрөөр “СҮРЬЕЭ ЭДГЭРДЭГ ӨВЧИН” сэдвээр гарын авлага бэлтгэн олшруулж хөдөөгийн малчин өрхүүдээр тарааж мэдээлэл өгсөн. Хүүхдийн цэцэрлэг дээр дархлаажуулалтыг товллын дагуу хүүхдэд хийлгэж байх, вакцинд хамруулах нь хүүхдэд хэрхэн	70%

			ашигтай талаар эцэг эх асран халамжлагч нарт сургалт хийж зөвөлгөө өгөв.	
13	Сар шинийн баяр болон ахмалын баярыг тохиолдуулан ахмадуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулах	Хууль хэрэгжсэн байх	Сар шинийн баяраар 80-аас дээш натай 13 ахмадад ЗДТГ-аас хүндэтгэл үзүүлсэн. Сумын ахмадын хороо БЗД-ийн 10-р хорооны ахмадыг хороотой шифийн харилцаа тогтоож 9 сарын 17-нд суманд ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлж олон талт үйл ажиллагаануудыг зохион байгуулж ахмадуудад хүндэтгэл үзүүлсэн.	100%
14	Сургууль, цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв мөн төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллах төрөл бүрийн ажил, арга хэмжээ зохион байгуулах	Үйл ажиллагаа зохион байгуулж үр дүнд хүрэх	Улаанбаатар хот, Говьсүмбэр аймаг дахь нутгийн зөвлөлтэй хамтран сар шинийн золгоог 3 сард зохион байгуулж нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. 4 сард ЭМТ-тэй хамтран нээлттэй хаалганы өдөр, 5 сард цэцэрлэг, ЕБС, ЭМТ, Соёлын төв, малчидтай хамтран “Инээж буй хүүхэд” хүүхдийн анхдугаар чуулган, 6 сард олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр Соёлын төвтэй хамтарч хүүхдүүдийн дунд “Миний бүтээл”, “Гоо охин”, “Бяцхан жентельмень”, зэрэг уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулсан. 9 сард ахмадын хороотой хамтран Ахмадын баяр, Соёлын төвтэй хамтран зүүн бүсийн цолгүй залуу бөхчүүдийн бөхийн барилдаан, 10 сард Монголын багш нарын баярын 52 дахь өдрийн баярын үйл ажиллагаа, иргэдийн спортын наадмыг Соёлын төвтэй хамтран тус тус зохион байгуулсан.	100%
15	Хүүхэд хамгааллын хамтарсан багийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж тайлагнаж ажиллах	Заалт нэг бүрээр хэрэгжсэн байх	Сумын хүүхэд хамгааллын хамтарсан багийг Сумын ИТХ-ын 2017 оны 11 сарын 27 ны өдрийн 39 дугаар тогтоолоор 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Дундговь аймагт 2018 оны 4 сарын 24,25-нд Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах 16 цагийн сургалтанд багаараа хамрагдаж гэрчилгээ авсан. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн 2018 оны ажлын төлөвлөгөөг сумын Засаг даргаар 3 сарын 22-нд батлуулж хэрэгжүүлж ажилласан байлаа. ЗДТГ-ын “Нээлттэй хаалга”-ны өдрөөр хүүхэд хамгааллын тухай хуулиар гарын авлага бэлтгэж 25 хүнд тараасан. Хэсгийн төлөөлөгч Т.Адъяабат дунд сургуулийн хүүхдүүдэд “Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр сургалт хийсэн. Хүүхэд хамгааллын хамтарсан баг нь 2018 онд хүүхэд рүү чиглэсэн 8 ажил төлөвлөж төлөвлөгөөний дагуу “Инээж буй хүүхэд” нэртэй хүүхдийн анхдугаар чуулганыг 2018 оны 5 сарын 16-нд амжилттай зохион байгуулсан. ГХУСАЗСЗөвлөлтэй хамтран ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хууль, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хууль-иар сургалт хийж “Замын хөдөлгөөний дүрэм”-р видео бичлэг үзүүлж сумын хүүхэд	100%

			хамгааллын хамтарсан багийн гишүүдийг танилцуулж, яаралтай түргэн тусламжид хандах утасны дугаарыг тэмдэглүүлэн хүүхдүүдтэй нээлттэй ярилцаж санал бодлыг сонсож ажиллалаа. 2018 оны 6 сарын 22-нд Жаргалан багийн нутаг дэвсгэрт болсон “Цагаан-Уул”-ын тахилга наадам, Аймгийн тахилгат “Баян-Уул” хайрханы тахилга наадам, сумын баяр наадамд наадмын морины комисстой хамтран ажиллаж уралдаанд оролцож байгаа хүүхдийн аюулгүй байдал, стандартын хувцас хэрэгсэлтэй, 7-оос дээш насны хүүхдийг уралдаанд оролцуулах, даатгалд хамруулсан байх, эцэг, эх асран хамгаалагчийн зөвшөөрөл зэргийг шалгаж хяналт тавьж ажиллалаа. ХХХБаг 4 удаа хуралдаж 6 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. Сумын хүүхэд хамгааллын бодлого боловсруулж ИТХ-д хүргүүлсэн.	
Долоо. Нийгмийн халамж, нийгмийн даатгал, улсын бүртгэлийн ажлын хүрээнд				
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлж биелэлтийг тооцож ажиллах	Хөтөлбөр хэрэгжиж үр дүнд хүрсэн байх	Үлийн цагаан оготонотой тэмцэх нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж 10 ажилгүй иргэнийг 10 хоног ажиллуулж 2800000 төгрөгийг олгож ажилласан. Ямаа самнах ажилд 6 иргэн 15 хоног ажиллаж 4,500,000 төгрөг, хонь ноослоход 10 иргэн 10 хоног ажиллаж 2,000,000 төгрөг, мөн худаг гаргах, хороо засаж сэлбэх ажилд 5 иргэн ажиллаж 1,000,000 төгрөг тус тус олгосон.ОНХС-ын хөрөнгөөр хийгдсэн өвс тэжээлийн агуулах барих ажилд ажилгүй 3 иргэн хамрагдаж 1200.000 төгрөгний санхүүжилт авсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгогддог жижиг зээлд 2 иргэн хамрагдаж 20.000.000 төгрөгний санхүүжилт авсан. Малжуулах төсөлд 2-р багийн иргэн С.Цолмон хамрагдаж 5000.000 төгрөгний бог мал худалдан авсан. Төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдтэй гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна.	100%
2	Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг цаг хугацаанд нь олгож ажиллах	Цаг хугацаандаа олгосон байх	Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийн талаар багийн иргэдийн нийтийн хурал болон мэдээллийн цагаар мэдээлэл хийж тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаанд нь шуурхай олгон ажиллаж байна. Одоогийн байдлаар 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа 46 эх, жирэмсэн 8, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 6, нийгмийн халамжийн тэтгэвэр 10, амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж 10, өрх толгойлсон эх эцгийн тэтгэмжид 5, абайнгын асаргаа шаардлагтай иргэнийг асарч байгаа 20, насны хишиг 52, эхийн алдар 1 одон 39, эхийн алдар 2-р одо 72, нийт 268 хувийн хэргийн бүрдэлтэй байна.	100%
3	Хүнсний эрхийн бичгээр хүнс олгож байгаа шалгарсан ААН-д хяналт тавьж ажиллах	Ажлын хариуцлага дээшилнэ.	“Нийгмийн эмзэг бүлэгт хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд ООТА-аар амьжиргааны түвшин тодорхойлох судалгаагаар сонгогдсон 10 өрхөд хүнсний талон олгож байгаа. "Сайн гашуун" ХХК нь уг 10 өрхийн 50 иргэнд хүнсний эрхийн бичгээр үйлчилдэг. Үйлчилгээ авдаг өрхийн хөдөлгөөнийг тухай бүр гаргадаг. Шилжиж ирээгүй 1 иргэн үйлчилгээ авч байсан	100%

			зөрчлийг арилгасан. Дэлгүүрийн үйлчилгээнд улсын мэргэжлийн хяналтын байцаагч, татварын байцаагч нарын хамт 1 удаа, мөн өөрөө хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ авч байгаа иргэдэд хяналт шалгалт хийсэн. Хяналтаар хугацаа дууссан болон муудсан бүтээгдэхүүн илрээгүй. Хүнсний талноор олгох 10 нэр төрлийн барааг тендерийн үнээр олгож байна.	
4	Ахмад настнуудыг нийгмийн халамж үйлчилгээнд бүрэн хамруулж, ахмадын санг бүрдүүлэх	Хууль хэрэгжсэн байх	Ахмад настнууд нийгмийн халамж үйлчилгээнд бүрэн хамрагдсан. 9 ахмад дотоодын рашаан сувилалд амарч хуулийн дагуу эмчилгээ сувилгаа зайлшгүй шаардлагтай ахмад настанд олгох үнийн 50% болох 1409.500 төгрөгийг эргүүлэн авсан, ахмадын амралтанд 13 ахмад хөнгөлөлттэй үнээр амарч сувилуулсан. Протез, ортопедийн хэрэгсэл олгоход 12 ахмад хамрагдаж 12514.000 төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн. Тэжээн тэтгэх үр хүүхэдгүй 1 ахмад түлээ түлшний хөнгөлөлтөд хамрагдсан. Засаг даргын захирамжаар ахмадуудыг баг, байгууллагат бүрэн хамруулсан. 57 ахмад настанд 4850.000 төгрөгийн насны хишиг олгосон.	100%
5	Ажилласан жил нөхөн тооцох ажиллагааг зохион байгуулж хамрагдвал зохих иргэдийг бүрэн хамруулах	Хууль хэрэгжсэн байх	УИХ-аас 2017 онд баталсан "Малчин ,хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль"-ийн хэрэгжилтийг 2019 оноос эхлүүлэх болсонтой холбогдуулан сумын хэмжээнд хамрагдах иргэдийн судалгааг гаргаж нөхөн тооцох хуудсаа наалгаагүй иргэдтэй утсаар холбогдон нийт 6 иргэний нийгмийн даатгалын дэвтрийг Дундговь аймгийн ЭМНДХэлтэсд хүргүүлж, мөн нөхөн тооцохын мөнгө төлөөгүй 2 иргэний өргөдлийг хүлээн авч шийдвэрлэж ажилласан.	100%
6	Малчид иргэдийг сайн дурын болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	Хууль хэрэгжсэн байх	СДД-ын шимтгэл 185 хүн хамрагдаж 17197800 төгрөгийн шимтгэлийн орлого, ЭМД-ын хураамж 156 хүн хамрагдаж 4980000 төгрөгийн орлого орсон. СДД болон ЭМ даатгалд сумын иргэд болон малчидыг хамруулах ажил зохион байгуулсан. Үүнд: 9 сард жил болгон болдог нийт 4 багийн иргэдийн нийтийн хуралд мэдээлэл хийсэн. 9 сарын 11 нд Нийгмийн даатгалын нээлттэй хаалганы өдөрлөгөөр хөдөлмөрчид ард иргэдэд сургалт зохион байгуулсан. 2018 оны 11сарын 28-30 хооронд 4-р багийн засаг дарга Мягмардоржтой хамтран хөдөөний айл өрхүүдээр явж эрүүл мэнд нийгмийн даатгалын талаар мэдээлэл хүргэж ажилласан. 2018оны 12сарын 07-11 хооронд 2018 оны жилийн эцсийн хүн ам, мал тооллогод 1-р багийн засаг дарга Жаргалмаа, Ундрахбаяр, Арьяабазар хамт явж нийгмийн даатгалын талаар малчидад тараах материал болон мэдээлэл хүргэн ажилласан.	100%
7	Хөнгөлөлттэй олгодог эмийн үнэнд хяналт тавьж иргэдэд хүртэх хүртээмж, зорилтот бүлгийн хүмүүсийг хамруулах, ил тод байх	Ажлын хариуцлага дээшилнэ.	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16,1,4 дэх заалт, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах сонгон шалгаруулалтанд орж ард иргэддээ 9 сарын 1-нээс эхлэн	100%

			үйл ажиллагаагаа жигдрүүлэн хөнгөлөлттэй эмээр үйлчилж эхэлсэн. Бүх эмч цахимаар жор илгээсний дагуу хөнгөлөлтийг олгож байна. Сард 254000 төгрөгний эмээр хөнгөлөлт олгох эрхтэй.	
8	Улсын бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулах	Хууль хэрэгжсэн байх	2018 онд төрөлт 20, гэрлэлт 1, нас баралт 7, иргэний үнэмлэх олголт 67, шилжин явсан 17 том хүн, хүүхэд 5, шилжин ирсэн 32, хүүхэд 9, иргэний үнэмлэх захиалга 58 бүртгэж олгосон байна. Бэлэглэх гэрээ 1, хамтран өмчлөх эрх хасуулах 3, байгууллагын удирдлага өөрчлөгдсөн 4 үйлчилгээг улсын бүртгэлийн санд оруулаад байна. Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, цаг хугацаанд нь үнэн зөв хийж ажиллалаа.	100%
Хэрэгжилт – 93,4%				

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР